



САЙХАН СУМЫН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2020-07-30 № САА-2020/04-НА-11
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Сайхан сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Сайхан сумын Монгол Ардын намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020562


Дүгнэлт

Сайхан сумын Монгол Ардын намын хорооны Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сайхан сумын Монгол Ардын намын хорооны мөрийн хөтөлбөр /...⁷... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сайхан сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ
2020 ОНЫ СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020.06.23

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ
ХҮЧЭЭ НЭГТГЭЭ**



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ

1.1. БАГА БОЛОН ӨСВӨР НАСНЫХАНД ЗОРИУЛСАН БОДЛОГО

- 1.1.1 Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөрийг дэмжиж ажиллана.
- 1.1.2 Цэцэрлэг, сургуулийг БНХАУ, Япон, Солонгос улсуудын ижил төрлийн байгууллагатай түншийн харилцааг тогтоож “Багш сурагч солилцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.1.3 Хүүхдийг багаас нь аймаг сумынхаа түүх, соёл, уламжлалыг мэддэг, хөдөлмөрт дуртай, нутаг орноороо бахархах үзэл хүмүүжилтэй, амьдралын зөв дадал хэвшилтэй, боловсролтой иргэн болгон төлөвшүүлэх “Бидний ирээдүй сайхан” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.1.4 “Эрүүл хүүхэд бидний ирээдүй” уриан дор хүүхэд бүрийг жил болгон эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт, шаардлагатай тохиолдолд шинжилгээнд хамруулан, эрүүл өсөж бойжих нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.1.5 Хүүхдийн нийтийн биеийн тамир, спортын өвөл, зуны наадам, “Гэрэлт ирээдүй”, “Бүжгийн ертөнц” зэрэг уламжлалт урлагийн арга хэмжээнүүдийн хамрах хүрээг нэмэгдүүлэн, шинэлэг арга хэлбэрээр уламжлал болгон зохион байгуулна.
- 1.1.6 Сумын номын сангийн нөөцийг үндэсний болон дэлхийн сонгодог уран зохиолын номуудаар баяжуулна.
- 1.1.7 Бичил байрнуудын дунд болон гэр хороололд хүүхэд багачуудын ая тухтай тоглох орчныг сайжруулна.

1.2. ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛСАН БОДЛОГО

- 1.2.1 Залуучуудын хөдөлмөрч, бүтээлч сэтгэлгээг хөхүүлэн дэмжиж “Бүтээлч Залуучууд” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 1.2.2 Өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор бичил бизнес эрхлэлтийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлнэ.



- 1.2.3 Сайхан суманд орон сууц барих иргэн аж ахуй нэгж байгууллагыг дэмжиж ажиллана.
- 1.2.4 Их дээд сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгссөн залуучууд, гадаад улсад сурч, ажиллаж байгаад ирсэн залуучуудын мэдлэг, туршлагыг бусадтай хуваалцах, нутагшуулах зорилгоор байнгын эргэх холбоотой байж орон нутгийн хөгжлийнхөө төлөө хамтран ажиллана.
- 1.2.5 Удам залгаж шинээр малчин, тариаланч болох залуучуудын сонирхлыг дэмжин хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй залуусыг бодлогоор дэмжинэ.
- 1.2.6 “Залуусын өдөр” өдөрлөгийг жил бүр зохион байгуулж залуучууд, оюутнуудын хөгжих, тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн клуб, холбоод, ТББ-ыг дэмжиж ажиллана.

1.3. ДУНД НАСНЫХАНД ЗОРИУЛСАН БОДЛОГО

- 1.3.1 Гэр бүлийн хөгжлийг дэмжих “Жаргалтай гэр бүл” хөтөлбөрийг сумын хэмжээнд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.3.2 Гэр бүлийн төв ажиллуулж гэр бүлийн хөгжил, амьдрах ухаан болон туршлага солилцох уулзалт, үзэсгэлэн, өөрсдийн бүтээл, бүтээгдэхүүний худалдаа, солилцоо зэрэг арга хэмжээг зохион байгуулна.
- 1.3.3 Аж ахуйн нэгж, албан байгууллагад ажиллагсдын дадлага туршлага, мэдлэгийг залуу боловсон хүчинд өвлүүлэх, залгамж халааг бий болгоход чиглэсэн “Эзэмшүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.4 Иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд дэмжиж ажиллана.
- 1.3.5 Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.3.6 Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, ядуу, нэн ядуу өрхийг малжуулах, гахай, шувуу, зөгий үржүүлэх зэрэг төсөл, хөтөлбөрт хамруулах талаар холбогдох байгууллагад уламжилна.
- 1.3.7 “Манай гудамж - Миний гэр” хөтөлбөр хэрэгжүүлж, айл өрхөөрөө хамтран бүтээлч ажил өрнүүлж, оршин суугаа орчноо тохижуулахад нь туслалцаа үзүүлнэ.



1.4. АХМАДУУДАД ЗОРИУЛСАН БОДЛОГО

- 1.4.1 Сумын хэмжээнд мод, бут, сөөг үржүүлэх, цэцэрлэгжүүлэхэд ахмадуудтай хамтран ажиллах, ногоон орчныг хамгаалах зэрэг нийтэд тустай ажил үйлчилгээ эрхлэх санал санаачилгыг дэмжиж хамтран ажиллана.
- 1.4.2 Жил бүр ахмадуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах арга хэмжээ авна.
- 1.4.3 Ахмад настны амралт, чөлөөт цагаа зөв, идэвхтэй ашиглахад чиглэсэн “Цэнгэг агаар” хөдөлгөөнийг дэмжин хамтран ажиллана.
- 1.4.4 Төрийн үйлчилгээ болон эмнэлгийн тусламж үйлчилгээг авахад ахмадуудад дугаар харгалзахгүй үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.4.5 Ахмадын чөлөөт цагийг өнгөрүүлэх “Ачлалт өргөө” сувиллын санхүүжилтийг улс, орон нутгийн төсөвт тусгуулах санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 1.4.6 Ахмадуудын амьдрал, ажлын туршлагыг хүүхэд, залуучуудад өвлүүлэх зорилго бүхий “Өвлүүлэн сургах” арга хэмжээг жил бүр зохион байгуулдаг болно.
- 1.4.7 Улс, аймаг, орон нутгаас ахмадуудын дунд зохион байгуулж буй урлаг, спортын уралдаан, тэмцээнд ахмадуудын санал санаачилгыг хөхүүлэн дэмжиж ажиллана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОДЛОГО

- 2.1. Сумын иргэд, олон нийтэд үйлчлэх байнгын “Нэг цонхны үйлчилгээ” байгуулан ажиллуулна.
- 2.2. Овоот Дөмбөн хороолол буюу Гавшгай 2-р багт шинээр багийн байр барих ажлын зураг төсөв, тооцоо судалгааг хийж, холбогдох байгууллагад санал тавьж шийдвэрлүүлнэ.
- 2.3. Өрхийн эмнэлгүүдийг стандартын шаардлага хангасан байртай болгох, анхан шатны оношилгоо хийх багаж, тоног төхөөрөмжөөр хангах санхүүжилтийн асуудлыг холбогдох шатны төсөвт тусгуулж, шийдвэрлэнэ.
- 2.4. Сайхан сумын төвийн ногоон байгууламжийг хамгаалах талаар журам боловсруулж сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулна.




- 2.5. Төр, төсвийн байгууллагуудын ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, туршлага эзэмшүүлэх зорилгоор сургалтад тогтмол хамруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 2.6. Төрийн албан хаагчдын урлаг, спортын наадмыг жил бүр шинэлэг хэлбэрээр зохион байгуулна.
- 2.7. Сумын орон нутаг сурталчлах танхимын үзмэрийн тоо нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 2.8. Төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авалтын тендерийн сонгон шалгаруулалт болон гүйцэтгэлийн үе шатны хяналтыг иргэдийн оролцоотойгоор шударгаар дүгнэж иргэдэд тайлагнадаг болно.
- 2.9. Орон нутгийн төсөв болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг иргэдийн оролцоотой төлөвлөн тэдний амин чухал хэрэгцээг хангахад зориулан зарцуулж, хянадаг журам тогтооно.
- 2.10. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг Даргын Тамгын газрын үйл ажиллагааг олон нийтэд ил, тод болгох, гаргаж буй эрх зүйн акт, баримт бичгүүдийг цахим хэлбэрт нээлттэй байршуулна.
- 2.11. Сумын төр, төсвийн байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлт, албан хаагчдын сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тодоор сонгон шалгаруулахад хяналт тавьж ажиллана.
- 2.12. Сумын газар олголтыг иргэн бүрд хүртээмжтэй олгох ажлыг зохион байгуулна.
- 2.13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 2.14. “Иргэдтэй уулзах өдөр”-ийг сумын хэмжээнд улирал тутамд зохион байгуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БОДЛОГО

- 3.1. Сумын тариалангийн талбайд тооллого хийж, дахин хуваарилалтад оруулж сумын иргэдэд хүртээмжтэйгээр эзэмшүүлэн тариаланч өрх, гэр бүлийг дэмжинэ.
- 3.2. Төмс, хүнсний ногоо, хадлангийн газрыг зохих журмын дагуу сумын иргэдэд давуу эрхээр эзэмшүүлнэ.



- 
- 3.3. Ногоочдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн бага оврын техник, хэрэгсэл бүхий техник үйлчилгээний төв байгуулах аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж ажиллана.
 - 3.4. Ногооны аж ахуй эрхэлдэг иргэдэд зориулсан дундын ногоо хадгалах зоорь барьж байгуулж, зоорины аж ахуйг хөгжүүлэх аж ахуйн нэгжтэй хамтарч ажиллана.
 - 3.5. Сумандаа үр, үржүүлгийн аж ахуйг бий болгох аж ахуйн нэгж байгууллагатай хамтарч ажиллана.
 - 3.6. Иргэдийн эзэмшиж ашиглаж байгаа ногооны газрыг өмчлүүлэх асуудлыг хуульчлахаар УИХ, Засгийн Газарт санал хүргүүлнэ.


ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙН БОДЛОГО

- 4.1. Малын үүлдэр угсааг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх ажлыг эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 4.2. Махны үүлдрийн үхэр, хонь үржүүлэх, мал бордох чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа малчин өрхийн аж ахуйг дэмжиж, өндөр ашиг шимт үүлдрийн хээлтэгч, хээлтүүлэгчтэй хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй хамтрах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
- 4.3. Мал эмнэлгийн үйл ажиллагааг чанаржуулж эрүүл малтай сум болно.
- 4.4. Малчид хадлангийн талбайг дунд хугацаагаар ашиглах талаар сумын хэмжээнд журам боловсруулж ИТХ-р батлуулж, хэрэгжүүлнэ.
- 4.5. Бэлчээрийг усжуулах, худгийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГО

- 5.1. Иргэдийг жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэсэн сургалт, семинарт хамруулна.
- 5.2. Иргэд, аж ахуйн нэгжийн үүсгэл санаачилгад тулгуурлан сумын хөгжилд онцгой ач холбогдолтой бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 5.3. Төмс, хүнсний ногоо угааж савлах, боловсруулалт хийх үйлдвэрийг байгуулах санхүүжилтийг улс, аймгийн төсөвт тусгуулах санал хүргүүлж, шийдвэрлэнэ.



- 
- 5.4. Ажлын байрыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч, хувийн хэвшлийн ААН, албан байгууллагуудтай барилгын материалын үйлдвэр байгуулах талаар хамтарч ажиллана.
 - 5.5. Хоёрдогч түүхий эдийн болон хуванцар, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах хувийн хэвшлийн санал санаачилгыг дэмжинэ.
 - 5.6. Арьс, шир, ноос, ноолуурт анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр цехүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
 - 5.7. Номгон тосгонд малын тэжээлийн үйлдвэр байгуулах ажлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжилна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. СУМЫН ХӨГЖИЛ

- 6.1. Сайхан сум болон Орхон сумын хоорондох хилийн цэсийн асуудлыг холбогдох байгууллагад уламжлан, эцэслэн шийдвэрлүүлнэ.
- 6.2. Сайхан сумын төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг цэгцлэх ажлыг ландшафт аргаар үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 6.3. Сайхан сумын хэмжээнд борооны ус зайлуулах үерийн далан шуудууг сэргээн засварлах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 6.4. Хот тохижилтын газрын орон тоо болон техник, машин механизмыг үе шаттайгаар нэмэгдүүлэн ажиллана.
- 6.5. Наадмын талбайг бүрэн шинэчлэх санхүүжилтийг аймгийн төсөвт тусгуулан, хэрэгжүүлнэ.
- 6.6. Гудамж талбайн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 6.7. Ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд хотын төв болон гэр хорооллын тодорхой хэсгийг камержуулна.
- 6.8. Иргэдийг стандартын шаардлага хангасан усаар хангах ажлын хүрээнд худгийн усанд зөөлрүүлэгч төхөөрөмж шинээр суурилуулна.
- 6.9. Хүүхдийн паркийг үе шаттайгаар шинэчлэн тохижуулна.
- 6.10. Сумын 1,2,3,4 багийн нутаг дэвсгэрт явган хүний гарц, замын тэмдэг тэмдэглэгээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
- 6.11. Гэр хорооллын ахуйн худгийг 24 цагийн ухаалаг системд шилжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.



- 6.12. Номгон тосгоны уурын зуухыг шинэчлэх, засварлах ажлыг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 6.13. Гэр хорооллын айл өрхийг хаягжуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 6.14. Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах ажлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 6.15. Сум дундын эмнэлгийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
- 6.16. Инженерийн шугам сүлжээнд шинэчлэл хийж, цэвэр бохир, дулаан, халуун хүйтэн усны шугам хоолойг бүрэн шинэчлэх ажлын зураг, төсөв тооцоо судалгааг хийж, санхүүжилтийг холбогдох шатны төсөвт тусгуулан, хэрэгжүүлнэ.
- 6.17. Орон сууцны дээврийн засвар болон гадна фасад дулаалгын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх талаар холбогдох газруудад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 6.18. Жимстэй хорооллыг төвийн дулааны шугам сүлжээнд холбох санхүүжилтийг холбогдох шатны төсөвт тусган, хэрэгжүүлнэ.
- 6.19. Сайхан сум болон Жимстэй хорооллын хооронд бетонон авто замыг шинээр барих ажлыг холбогдох байгууллагад уламжлан, шийдвэрлүүлнэ.
- 6.20. Гэр хорооллын айл өрхүүдийг цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбох тооцоо судалгааг хийж, санхүүжилтийг шийдвэрлэн, хэрэгжүүлнэ.
- 6.21. Гэр хорооллын сайжруулсан шороон замыг хатуу хучилттай зам болгох саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, төсөвт тусгуулах арга хэмжээ авна.
- 6.22. Гэр хороололд хүүхдийн цэцэрлэг шинээр барих санхүүжилтийг улсын төсөвт тусгуулах санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 6.23. Бичил хорооллын дунд эрүүл ахуйн шаардлага хангасан ангилах ялгах зориулалт бүхий хогийн сав шинээр хийнэ.
- 6.24. Бичил хорооллын дунд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

САЙХАН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

